# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/86/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт.........3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.........5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........10
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.........10
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.........10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.........10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.........11
4. Аудитын тайлан.........14
   4.1 Ерөнхий зүйл.........14
   4.2 Материаллаг байдал.........14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.........14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.........14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.........15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.........16
5. Аудитын илрүүлэлт.........18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.........19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400, Увс аймаг. Улаангом сум.
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17.
E-mail: uvs@audit.gov.mn

2023. 02. 25 № УВА-2023/26/ХА-СТА-ТУЗ
танай_____________-ны №_______________-т

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Соёл, урлагийн газар нь төсвийн хөрөнгөөр 700.0 мянган төгрөгөөр видео контент хийсэн, 300.0 мянган төгрөгөөр “Өглөөлөг” сургалт, уулзалтад зориулан үзэг балын сав худалдан авч тараасан, 766.1 мянган төгрөгийн 6 удаагийн сургалтад цай, хоолны зардалд гаргасан, 10711.5 мянган төгрөгийн 3290 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үүлдээгүй, зарцуулалтын тооцоо бодохгүйгээр хяналтгүй зарцуулсан, архив-бичиг хэрэг, нярвын нэг бүтэц, орон тоог хэтрүүлэн архив-бичиг хэрэг, нярав гэсэн 2 орон тоо болгон давхардуулан ажиллуулан 11.069.3 мянган төгрөгийн цалинг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад ”Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалтад “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4 дэх заалтад “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг,

0200000612

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.1.5 "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.7 дахь хэсэгт "Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Соёл, урлагийн газрын удирдлага өөрчлөгдсөн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,716,290.00** | **2,065,787.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 3,000,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 3,000,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 3,000,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 716,290.00 | 2,065,787.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 716,290.00 | 2,065,787.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 342,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 374,290.00 | 1,233,287.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 832,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 5,005,700.00 | 75,052,226.04 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,005,700.00 | 75,052,226.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,005,700.00 | 75,052,226.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 00.00 | 00.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,005,700.00 | 30,609,700.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -4,290,498.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,000,000.00 | 12,628,989.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -1,654,992.45 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 00.00 | 40,999,370.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -4,740,342.00 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 00.00 | 00.00 |
| 39217 | Ном | 00.00 | 00.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 1,500,000.00 |
| 39301 | Программ хангамж | 00.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 8,721,990.00 | 77,118,013.04 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 8,721,990.00 | 77,118,013.04 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 8,721,990.00 | 77,118,013.04 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8,721,990.00 | 77,118,013.04 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 00.00 | 8,721,990.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 8,721,990.00 | 68,396,023.04 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 8,721,990.00 | 77,118,013.04 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **20,300,000.00** | **322,999,489.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **12,532,989.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | **12,532,989.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 12,532,989.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,3000,000.00** | **310,466,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 213,066,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 213,066,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,500,000.00 | 97,400,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00 | 97,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,000,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 12,800,000.00 | |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,800,000.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **11,578,010.00** | **254,603,465.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,578,010.00** | **254,603,465.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,816,343.00 | 211,964,371.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,191,878.00 | 130,016,166.02 |
| 210101 | Үндсэн цалин | 3,191,878.00 | 95,737,079.67 |
| 210102 | Нэмэгдэл | | 13,655,422.35 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 12,017,500.00 |
| 210104 | Урамшуулал | | 8,606,164.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 398,985.00 | 16,248,256.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 271,309.88 | 11,048,815.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,918.78 | 1,299,859.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,535.02 | 1,039,887.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,383.76 | 259,971.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 63,837.56 | 2,599,721.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 4,478,200.00 |
| 210304 | Байрны түрээс | | 4,478,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,642,480.00 | 17,387,967.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 170,000.00 | 2,211,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,472,480.00 | 10,711,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,640,867.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 33,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,790,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,996,000.00 | 10,734,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,996,000.00 | 10,734,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 349,000.00 | 617,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 349,000.00 | 617,450.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,238,000.00 | 32,482,332.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 21,400,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,238,000.00 | 396,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 10,685,832.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 761,667.00 | 42,639,093.98 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 4,215,971.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,215,971.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 761,667.00 | 38,423,122.98 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 761,667.00 | 37,298,742.98 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 1,124,380.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,124,380.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **8,721,990.00** | **68,396,023.04** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **8,721,990.00** | **68,396,023.04** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **20,300,000.00** | **310,466,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,300,000.00** | **310,466,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 213,066,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 213,066,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,500,000.00 | 97,400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00 | 97,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,000,000.00 | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 12,800,000.00 | |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,800,000.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **12,294,300.00** | **243,767,130.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,294,300.00** | **243,767,130.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **11,532,633.00** | **201,128,036.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,191,878.00 | 130,016,166.02 |
| 210101 | Үндсэн цалин | 3,191,878.00 | 95,737,079.67 |
| 210102 | Нэмэгдэл | | 13,655,422.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 12,017,500.00 |
| 210104 | Урамшуулал | | 8,606,164.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 398,985.00 | 16,248,256.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 271,309.88 | 11,048,815.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,918.78 | 1,299,859.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,535.02 | 1,039,887.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,383.76 | 259,971.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 63,837.56 | 2,599,721.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 4,478,200.00 |
| 210304 | Байрны түрээс | | 4,478,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,984,480.00 | 15,036,964.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 512,000.00 | 1,869,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,472,480.00 | 7,711,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,640,867.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 33,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,781,397.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 374,290.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 374,290.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,996,000.00 | 10,734,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,996,000.00 | 10,734,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 349,000.00 | 2,817,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 349,000.00 | 1,317,950.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,238,000.00 | 21,796,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 21,400,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,238,000.00 | 396,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **761,667.00** | **42,639,093.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 4,215,971.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,215,971.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 761,667.00 | 38,423,122.98 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 761,667.00 | 37,298,742.98 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 1,124,380.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,124,380.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,005,700.00** | **66,699,370.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,005,700.00** | **66,699,370.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,005,700.00** | **66,699,370.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,005,700.00 | 66,699,370.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-5,005,700.00** | **-66,699,370.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 3,000,000.00 | |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | | | | |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 8,721,990.00 | | 8,721,990.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | 8,721,990.00 | | 8,721,990.00 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | | 8,721,990.00 | | 8,721,990.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | 8,721,990.00 | | 8,721,990.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | | 68,396,023.04 | | 68,396,023.04 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | 77,118,013.04 | | 77,118,013.04 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| **ЭЗА** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | |
|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 209,680,500.00 | 209,680,500.00 | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 209,680,500.00 | 172,501,786.02 | 37,178,713.98 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 209,680,500.00 | 172,501,786.02 | 37,178,713.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 151,902,000.00 | 130,016,166.02 | 21,885,833.98 |
| 210101 | Үндсэн цалин | 101,036,800.00 | 95,737,079.67 | 5,299,720.33 |
| 210102 | Нэмэгдэл | 30,800,000.00 | 13,655,422.35 | 17,144,577.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,200,000.00 | 12,017,500.00 | 1,182,500.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 6,865,200.00 | 8,606,164.00 | -1,740,964.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,325,200.00 | 16,248,256.00 | 5,076,944.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,501,200.00 | 11,048,815.80 | 3,452,384.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,706,000.00 | 1,299,859.31 | 406,140.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,364,800.00 | 1,039,887.99 | 324,912.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 341,200.00 | 259,971.32 | 81,228.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,412,000.00 | 2,599,721.58 | 812,278.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,318,400.00 | 4,478,200.00 | 840,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 111,400.00 | | 111,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 509,100.00 | | 509,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 219,700.00 | | 219,700.00 |
| 210304 | Байрны түрээс | 4,478,200.00 | 4,478,200.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,668,300.00 | 7,924,714.00 | 743,586.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,634,600.00 | 1,617,400.00 | 17,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,204,000.00 | 851,750.00 | 352,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,761,100.00 | 1,640,867.00 | 120,233.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 33,300.00 | 33,300.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,500.00 | | 144,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,890,800.00 | 3,781,397.00 | 109,403.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,700,000.00 | 1,700,000.00 | |
| 210602 | Тавилга | 1,700,000.00 | 1,700,000.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12,000,000.00 | 7,854,000.00 | 4,146,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,000,000.00 | 7,854,000.00 | 4,146,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,935,400.00 | 2,817,950.00 | 117,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,435,400.00 | 1,317,950.00 | 117,450.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,500,000.00 | 1,500,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,831,200.00 | 1,462,500.00 | 4,368,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,435,200.00 | 1,066,500.00 | 4,368,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 396,000.00 | 396,000.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,386,000.00** | **3,265,971.00** | **120,029.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,386,000.00 | 3,265,971.00 | 120,029.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 11 | | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | | |
| 620004 | Гэрээт ажилтан | | | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **96,275,620.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **96,275,620.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 95,325,620.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 7,112,250.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | | 252,500.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 6,859,750.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 64,999,370.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 58,799,370.00 | |
| 210602 | Тавилга | | 6,200,000.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 2,880,000.00 | |
| 210701 | Гадаад албан томилолт | | 00.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,880,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 20,334,000.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 20,334,000.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **950,000.00** | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 950,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 950,000.00 | |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 97,400,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 97,400,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 97,400,000.00 | |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Соёлын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, биет болон биет бус өвийг нээн илрүүлж хадгалан хамгаалах, өвлөн уламжлах соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжих орон нутгийн соёлын бодлогыг төрийн соёлын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхэд оршино. Үндэсний түүх, өв соёлын онцлогийг агуулсан мэдлэг мэдээлэлд суурилсан бүтээлч ажил өрнүүлэх, Соёлын өвийг хадгалж, хамгаалах өвлөн уламжлах баяжуулан хөгжүүлэх зорилготой байгууллага юм.

Харьяалах нутаг дэвсгэрийнхээ соёл урлагийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр Соёлын талаар баримталж буй бодлогыг орон нутгийн хэтийн төлөвтэй уялдуулан ажилладаг байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Соёлын яамны Стратеги төлөвлөгөө 2021-2024 он, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль , Статистикийн тухай хууль, Авлигын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт хэвийн байна.

Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл, урлаг газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,396.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлт нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон шилжүүлэн авсан үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 3,000.0 | | -3,000.0 |
| Бараа материал | 716.3 | 2,065.8 | 1,349.5 |
| Үндсэн хөрөнгө | 5,005.7 | 75,052.2 | 70,046.5 |
| **Нийт хөрөнгө** | **8,722.0** | **77,118.0** | **68,396.0** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 8,722.0 | 77,118.0 | 68,396.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **8,722.0** | **77,118.0** | **68,396.0** |

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгө болон авлаг дансны үлдэгдэл байхгүй байна. Авлага дансны үлдэгдэл 3,000.0 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах шатах тослох материалын авлагыг тайлант хугацаанд барагдуулсан байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 2,065.8 мянган төгрөг болж 1,349.5 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 859.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 832.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Энэ нь ажилтан албан хаагчдын албан хэрэгцээнд авсан хангамжийн зүйлс материалыг ажилтан тус бүрээр картлан аж ахуйн материал дансанд бүртгэсэн, танилцуулга байгууллагын мэдээллийн самбарыг бусад хангамжийн материалын дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 75,052.2 мянган төгрөг болж 70,046.5 мянган төгрөгөөр өссөн нь 68,199.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр худалдаж авсан, 2,865.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан болон хөрөнгө оруулалтаар 9,667.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, 10,685.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 77,118.0 мянган төгрөг болж 68,396.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 216,062.2 мянга, нийт зардлыг 216,062.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2,995.7 мянган төгрөгөөр бууруулж, 213,066.5 мянган төгрөг болгон тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 213,066.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 213,066.5 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 175,767.8 мянган төгрөг буюу 82.4 хувьтай байна. Үйл ажиллагааны зарцуулагдаагүй үлдэгдэл 37,298.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс нэмэгдэл урамшуулал | 151,902.0 | 130,016.2 | 21,885.8 | 85.5 |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,325.2 | 16,248.3 | 5,076.9 | 76.1 |
| 3 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 5,318.4 | 4,478.2 | 840.2 | 84.2 |
| 4 | Хангамж бараа материалын зардал | 8,668.3 | 7,924.7 | 743.5 | 91.4 |
| 5 | Эд хогшил урсгал засварын зардал | 1,700.0 | 1,700.0 | 0 | 100 |
| 6 | Томилолт, зочны зардал | 12,000.0 | 7,854.0 | 4,146.0 | 65.4 |
| 7 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,935.4 | 2,817.9 | 117.4 | 96.0 |
| 8 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,831.2 | 1,462.5 | 4,368.7 | 25 |
| 9 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэг | 3,386.0 | 3,266.0 | 120.0 | 100 |
| | **Нийт** | **213,066.5** | **175,767.8** | **37,298.7** | **82.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв буюу байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 97,400.0 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 252.5 мянга, тээвэр шатахууны зардалд 6,859.7 мянга, багаж, техник хэрэгслийн зардалд 58,799.4 мянга, тавилга хэрэгслийн зардалд 6,200.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 2,880.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 20,334.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 950.0 мянга, нийт 96,275.6 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 1,124.4 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

***3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн***

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөр тооцож 2,130.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардал 254,603.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 2,546.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,036.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Соёл, урлагийн газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг аудитын тайлангийн Аудитын илрүүлэлт хэсэгт тусгасан болно.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Соёл, урлагийн газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, мэдээлэл оруулах хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Соёл, урлагийн газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Соёл, урлагийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Соёл, урлагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчил гараагүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд албан томилолтын хуудасгүйгээр шатахууны зардал гарган хөдөө сумдаар явсан байна. Дараагийн аудитаар албан томилолтын зардлыг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,546.8 мянган төгрөгийн 6 зөрчил[1] илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,477.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 11,069.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.7 дахь хэсэгт "Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг зөрчин төсвийн хөрөнгөөр 700 000 төгрөгөөр видео контент хийсэн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.
2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн дугаар 43 тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг зөрчин төсвийн хөрөнгөөс 300,000 төгрөгөөр "Өглөөлөг" сургалт, уулзалтад зориулан үзэг балын сав худалдан авч тараасан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 5.2 Албан шаардлага

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн дугаар 43 тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.2.3 дахь заалтад “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг зөрчин төсвийн хөрөнгөөр 766 047 төгрөгийн 6 удаагийн сургалт, даргын өрөөний цай хоолны зардал гаргасан зөрчил илэрсэнд зөрчлийн таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болголоо.

2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжилга, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.2.3 дахь заалтад “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг тус тус зөрчин төсвийн хөрөнгөөр 10 711 500 төгрөгийн 3290 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үүлдээгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй, хяналтгүйгээр зарцуулсанд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болголоо.
3. Аудитаар илэрсэн зөрчлүүдэд холбогдуулан Соёл, урлагийн газрын нягтлан бодогч Б.Ундармаад Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Соёл урлагийн газар нь архив-бичиг хэрэг, нярвын нэг бүтэц, орон тоог хэтрүүлэн архив-бичиг хэрэг, нярав гэсэн 2 орон тоо болгон давхардуулан ажиллуулан 11.069.3 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2, 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 39.1.2 заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангаж, нотлох баримтын хамт 2023 оны 3 дугаар сарын 25–ны өдрийн дотор манай байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийн хөрөнгөөр 700,000 төгрөгөөр видео контент хийсэн | 1 | 700.0 | 1 | 700.0 | | | | | | | | |
| төсвийн хөрөнгөөр 300,000 төгрөгөөр "Өглөөлөг" сургалт, уулзалтад зориулан үзэг балын сав худалдан авч тараасан | 1 | 300.0 | 1 | 300.0 | | | | | | | | |
| төсвийн хөрөнгөөр 766 047 төгрөгийн 6 удаагийн сургалт, даргын өрөөний цай хоолны зардал гаргасан | 1 | 766.0 | | | 1 | 766.0 | | | | | | |
| төсвийн хөрөнгөөр 10,711,500 төгрөгийн 3290 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үүлдээгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан | 1 | 10,711.5 | | | 1 | 10,711.5 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Соёл, урлагийн газрын нягтлан бодогч Б.Ундармаа хариуцлага тооцуулах тухай | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| Бүтэц, орон тоо хэтрүүлэн ажилласан байна | | | | | | | 1 | 11,069.3 | | | | |
| Дүн | 6 | 23,546.8 | 2 | 1,000.0 | 2 | 11,477.5 | 1 | 11,069.3 | 1 | - | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТАМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2023 оны 02 сарын 25-ны өдөр

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 01/16/А2070457 Улаангом
УВА-2023/В6/НА-ОТА-0443

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газар нь төсвийн хөрөнгөөр 766,047 төгрөгийн 6 удаагийн сургалтын хоол, цайны зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтад "Хуульд нийцээгүй шийдвэр гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.2.3 дахь заалтад "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт "Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолыг мөрдөн

²*Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317*

ажиллаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[2] т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Ундармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

| | |
|---|---|
| АУДИТОР | ...ОУШ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | М...АТ-АМГАЛАН |
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | М...АТСУУРЬ |

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 03/18/А2070457    Улаангом
УВА-2023/86/НА-СУА-ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газар нь төсвийн хөрөнгөөр 2022 онд 10,711,500 төгрөгийн 3290 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтад "Хуульд нийцээгүй шийдвэр гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжилга, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.2.3 дахь заалтад "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.7 дэх заалтад "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажаагүй", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл

[2]*Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317*

0200000063

зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[2] т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Ундармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР Р.ЮУШ

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 25 өдөр Дугаар 02/17/А2020457 УВА 2023/86/НА СЗА-ТШЗ Улаангом

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Соёл урлагийн газрын нягтлан бодогч Б.Ундармаагийн ажлын хариуцлагатай холбоотой дараах зөрчил илэрсэн Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр 766,047 төгрөгийн 6 удаагийн сургалтын хоолны зардал, даргын өрөөний цай материалын зардал гаргасан.
2. Төсвийн хөрөнгөөр 2022 онд 10,711,500 төгрөгийн 3200 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үүлдээгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан.
3. Төсвийн хөрөнгөөр 700,000 төгрөгийн видео контент хийсэн.
4. "Өглөөлөг" уулзалт, сургалтад зориулан 300,000 төгрөгийн үзэг балын сав худалдан авч тараасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "Үнэн, зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжилга, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.2.3 дахь

*²Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317*

0200000059

заалтад “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх”, 1.7 дахь хэсэгт “Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

3. Соёл урлагийн газрын нягтлан бодогч Б.Ундармаад сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[2]т ирүүлэхийг Соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунцэцэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР ... ЮУШ

АУДИТЫН МЕНЕЖЕР М. ...Т-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М. ...АТСУУРЬ

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 01/4/А2070457 УВА-2023/26/НА-СТА-ЭШ 3 | Улаангом

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газар нь төсвийн хөрөнгөөр видео контент хийсэн 700,000 төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 14 дэх хэсэгт "Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, худалдах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8 дахь заалтад "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

[1]Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

0200500072

1. Хууль тогтоомж зөрчин төсвийн хөрөнгөөр видео контент хийсэн 700000 /долоон зуун мянга/ төгрөгийг Соёл урлагийн газрын даргаар ажиллаж байсан А.Баярмагнай, нягтлан бодогч Б.Ундармаа нараар төлүүлж Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Ундармаа нарт хариуцуулав.

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР В.АЮУШ

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 02 сарын 28 өдөр | Дугаар 02/15/А2070457 УВА-2023/26/НА-СТА-ТИЗ | Улаангом

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газар нь “Өглөөлөг” уулзалт, сургалтаар 300,000 төгрөгийн үзэг балын сав худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтад “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.5-т “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-т “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сургалтын үеэр бэлгэнд зарцуулсан 300,000 /гурван зуун мянга/ төгрөгийг Соёл урлагийн газрын даргаар ажиллаж байсан А.Баярмагнай, нягтлан бодогч Б.Ундармаа нараар төлүүлж Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

[1]Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

0200500069

2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Ундармаа нарт хариуцуулав.

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР Г.АЮУШ

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ